

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	4
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.12. Шилэн дансны мэдээлэл	9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3. Менежментийн захидал	10
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	13
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	13
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	14
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	16
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	18
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	19
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	20
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	23

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БСШУСЯ	Боловсрол Соёл Шинжлэх Ухаан Спортын Яам
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ МУЗЕЙН
ЗАХИРАЛ Д.СҮХБААТАР ТАНАА

2020. 02. 18 № 06/515
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 -д заасны дагуу Монголын үндэсний музейн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Монголын үндэсний музейн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн.

Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Монголын үндэсний музейн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Монголын үндэсний музей нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон бусад стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Монголын үндэсний музейн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Захирал Д.Сүхбаатар Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох, үндсэн үйл ажиллагааны орлогыг төлөвлөх, цалин хөлсний талаархи зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монголын үндэсний музейн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Монголын үндэсний музейн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 24-нөөс 2020 оны 02 дугаар сарын 20-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Пийк ОМ аудит” ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Монголын үндэсний музейн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Пийк ОМ аудит ХХК-д 2020 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 38 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Монголын үндэсний музейн үйл ажиллагааны эрхэм зорилго нь өөрийн цуглуулгыг шинжлэх ухааны арга зүйд тулгуурлан судалж, цуврал бүтээлүүд хэвлүүлэх, үзүүлэнгийн

танхимуудыг сайжруулан олон улсын стандартад нийцүүлэх, археологи, түүх, угсаатны хээрийн болон суурь судалгааны ажлыг гүнзгийрүүлэн олон улсын түвшинд хамтран ажиллах, хээрийн болон суурь судалгаанд шаардлагатай орчин үеийн тоног төхөөрөмжүүдтэй болох, түүнийг ашиглах арга зүйд суралцах, судлаачдыг дотоод гадаадад нарийн мэргэжлийн сургалтанд хамруулахад оршино.

Монголын үндэсний музейн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Соёлын өвийг хадгалж хамгаалан хойч үедээ уламжлуулах
- Иргэдийн оюуны тодорхой эрэлт хэрэгцээг хангах

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой;
- Нийгмийн даатгалын тухай хуулиар нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээтэй холбоотой;
- Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдад төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох, илүү цагийн нэмэгдэл хөлс олгох, ур чадварын нэмэгдэл олгохтой холбоотой;
- Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдад шагнал, урамшуулал олгохтой холбоотой;
- Сангийн Сайдын 2019 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн 74 тоот тогтоолоор төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгахтай холбоотой;

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Монголын үндэсний музейн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Монголын үндэсний музейн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Acolous 3.0” программ хангамж ашигладаг байна.

Монголын үндэсний музейн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Монголын үндэсний музейн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 8 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийг 2018 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн дүн 1,388,544.0 мянган төгрөгөөс тооцон 13,885.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 21,096.2 мянган төгрөгөөр тооцсон нь тайлант оны үр дүнгийн бодит зардлыг суурь үзүүлэлт болгон сонгосонтой холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Монголын үндэсний музейн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 433,814.4 мянган төгрөгөөр буюу 4.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан урьдчилж төлсөн тооцоо, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	13,545.7	2,592.0	(10,953.7)
Урьдчилгаа		21,105.8	21,105.8
Бараа материал	200,923.7	316,685.3	115,761.6
Үндсэн хөрөнгө	8,661,746.5	8,969,647.2	307,900.7
Нийт хөрөнгө	8,876,215.9	9,310,030.3	433,814.4
Өр төлбөр		4,565.6	4,565.6
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	8,876,215.9	9,305,464.7	429,248.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	8,876,215.9	9,310,030.3	433,814.4

Авлага дансны үлдэгдэл буурсан нь татварын хэлтэст 2018 оны илүү төлөлтийг барагдуулсан байна. Авлага дансны үлдэгдэлд 2019 онд үүссэн 2,592.0 мянган төгрөгийн авлага нь байгууллагаас авах авлага байна.

Урьдчилгаа тооцоо дансны үлдэгдэл 21,105.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 364 тоот тогтоол, БСШУССайдын 2019 оны 10 дугаар сарын 11-ны өдрийн А/642 тоот тушаалаар Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын Хориг уулын орчимд орших Эзэнт гүрний үед холбогдох олдворыг авран хамгаалах малтлага судалгаа хийхэд зориулан 144,00.0 мянган төгрөгийг санхүүжилтээс “Грийн химистри” ХХК-тай 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн №СН-19/62 тоот худалдан авах гэрээний дагуу бараа нийлүүлэх хугацаа хойшлогдсоноос шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн архелогийн судалгаанд ашиглагдах бараа материал бэлтгэснээс шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй бараа материал байхгүй байна. 2019 оны эцэст БСШУСЯ-наас архелогийн судалгаанд 144,000.0 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлснээр бараа материалын худалдан авалт хийж бараа материалын нөөц үүсгэсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь хандив тусламжаар дийлэнх хувь нь бэлтгэгдсэнээс шалтгаалжээ. Хөрөнгө оруулалтаар 147,002.0 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй хүлээн авсан 440,248.3 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

ТӨБЗГ-ын 2019 оны 5 сарын 21-ний 202 тоот тогтоолоор 24,782.1 мянган төгрөгийн суудлын авто машиныг Орхон АЗЗА төрийн өмчит хувьцаат компанид балансаас балансанд шилжүүлсэн, ТӨБЗГ-ын 2019 оны 5 сарын 20-ны А-5/1381 тоот тогтоолоор 17,206.8 мянган төгрөгийн хөрөнгө актлаж данснаас хасагдсан байна.

Биет бус хөрөнгө тайлант онд 550.0 мянга төгрөгөөр архив, албан хэрэг хөтлөлтийн программ хангамж худалдан авсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 4,565.6 мянган төгрөгөөр өссөн нь цалин хөлснөөс суутгасан хувь хүний орлогын албан татвараас үүссэн өр 4,395.9 мянган төгрөг, цахилгааны үлдэгдэл төлбөр 169.6 мянган төгрөг зэргээс шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 9,305,464.7 мянган төгрөг болж 429,248.8 мянган төгрөгөөр өссөн нь БСШУСЯмны хөрөнгө оруулалтаар музейн дээврийн их засварт 112,382.1 мянга, Хятад улсаас хандиваар тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл 176,771.2 мянга, Умард монгол төслийн хүрээнд түүх соёлын зүйлс 151,095.0 төгрөгөөр нэмэгдсэнээс тус тус шалтгаалжээ.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга 1,685.4 мянган төгрөгийн бичилт нь өмнөх оны үндсэн хөрөнгийн элэгдлийн тооцоололтой холбоотой байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монголын үндэсний музей нь тайлант 2019 онд 780,603.8 мянган төгрөгийн үндсэн үйл ажиллагааны орлогыг бүрдүүлсэн бөгөөд орлогын төлөвлөгөө батлагдаагүй байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 1,007,098.3 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1,007,098.3 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1,007,098.3 мянган төгрөгийг улсын төвлөрсөн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 944,634.7 мянган төгрөг буюу 93,8 хувьтай байгаа нь цалин хөлс ба нэмэгдэл урамшууллын зардал 52,652.6 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардал 6,969.5 мянга, байр ашиглахтай холбоотой тогтмол зардал 166.5 мянга, хангамж бараа материалын зардал 183.9 мянга, бусдаар гүйцэтгэсэн ажил үйлчилгээний төлбөрт 2,490.9 мянган төгрөгөөр тус тус зардлыг хэмнэлтээс шалтгаалсан байна.

Нэмэлт төсөв: Гадаад төсөл хөтөлбөрөөс 67,628.9 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 213,397.9 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 780,603.8 мянга, нийт 1,061,630.7 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалд 343,180.0 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлсөн шимтгэлд 40,424.6 мянга, хангамж бараа материалын зардал 63,635.7 мянга, нормативт зардалд 1,424.1 мянга, эд хогшил худалдан авах зардалд 286,613.4 мянга, томилолт зочны зардалд 19,450.0 мянган, бусдаар гүйцэтгэсэн ажил үйлчилгээний төлбөр 169,840.0 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 109,761.8 мянга,

нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 13,220.0 мянга, нийт 1,047,949.6 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 13,681.1 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 8 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 7 эрсдэл тодорхойлж нийт 15 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 88,982.4 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 68,369.1 мянган төгрөгийн алдааг залруулж, 1,609.4 мянган төгрөгийн зөрчилд 2 акт тогтоож, 7,157.6 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 11,846.3 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө. Үүнд:

Аудитаар орлогын данстай холбоотой 36,387.9 мянга, дотоод хяналттай холбоотой 21,105.8 мянга, балансын данстай холбоотой 2,640.0 мянга, зардлын данстай холбоотой 8,235.4 мянган төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулга хийлгэв.

1. Тайлант онд 2,592.0 мянган төгрөгийн авлага, 4,565.6 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “*Төсвийн зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: зөрчлийг арилгах албан шаардлага өгөх

2. Ээлжийн амралтаа биеэр эдлээгүй ажилтнуудад 1,239,464 төгрөгийн цалинг давхардуулан олгосон байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “*Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах*”, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 тоот тушаалаар батлагдсан “*Ээлжийн амралт олгох заавар*”-ын 13-т “*Ажил олгогч нь ажилтанг ажлаас халагдахаас бусад тохиолдолд болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол биеэр эдлээгүй ээлжийн амралтын оронд мөнгөн олговор олгож болохгүй*” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалинг нөхөн төлүүлэх, төлбөрийн акт тогтоох.

3. Албан томилолтыг тогтоосон хэм хэмжээнээс илүү тооцсон, мөн зочид буудлын анхан шатны баримтыг давхардуулан нийт 370.0 мянган төгрөг олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*”, 13.7-д “*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон албан томилолтыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

Аудитаар илэрсэн 11,846.3 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 4 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

- Сан хөмрөгийн эрхлэгчээр ажиллаж байсан Б.Энхбат өөрийн хариуцаж байсан сан хөмрөгөөс түүхийн үнэт үзмэр болох эд өлгийн зүйлийг хууль бусаар завшин үрэгдүүлж 44,905.5 мянган төгрөгийн хохирол учруулж хариуцагч нь 2019 оны 01 дүгээр сарын 02-нд нас барсан байна. Шүүхийн шийдвэрээр 35,028.6 төгрөг өрийг барагдуулсан ба 2019 оны улсын хэмжээнд сан хөмрөгийн тооллого явагдсан боловч санхүүгийн тайлан дахь түүх соёлын дурсгалт зүйл дансанд биетээр байхгүй 44,905.5 мянган төгрөгийн 2009 оны 10 сарын 27-ны жагсаалт бүхий 1007 ширхэг үзмэр байна.

- 2019 оны үндсэн үйл ажиллагааны орлогыг төлөвлөгөөгүй байгаа нь Сангийн Сайдын 2019 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн 74 тоот тушаалын 3.4.3-д “Үндсэн үйл ажиллагааны буюу байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэх явцад бий болдог жил бүр давтагдах шинжтэй тогтмол орлогыг төсөвт тусгахгүй орхигдуулах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Дээрх 2 асуудлыг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Монголын үндэсний музейн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 126 мэдээллийг хугацаанд нь, 18 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан нь шилэн дансны цахим систем засвар хийгдсэнээс шалтгаалсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар акт, албан шаардлага өгөөгүй байна.

Нийт 2 зөвлөмж өгснөөс 1 зөвлөмжийг хэрэгжүүлж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх гэсэн зөвлөмжийн хэрэгжилт 50 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Монголын үндэсний музейн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Залруулагдаагүй алдаа зөрчлийн дүн бидний тогтоосон материаллаг байдлын түвшингээс бага байгаа тул зөрчилгүй дүгнэлт өгч байна.

“Зөрчилгүй” дүгнэлт

Монголын үндэсний музейн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. *Балансын данстай холбоотой асуудал*

1.1. Илрүүлэлт:

2019 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангаар гэрээнд заасан ажлаа тайлагнаагүй ажилтанд цалин бодсон боловч гарт олгоогүй 1,453.0 мянган төгрөгийн цалинг цалингийн өглөг дансанд тусгаагүй, касс бэлнээр хадгалсан байсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*”, 13.7-д “*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

1.2. Эрсдэл:

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, холбогдох хууль зөрчигдөх

1.3. Өгсөн зөвлөмж:

Гэрээт ажилтнуудад цалин хөлс тооцохдоо хийсэн ажлын тайланг холбогдох албаны даргаар хянуулж байх, анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэхгүй байх.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Цаашид дээрх зөрчлийг гаргахгүй ажиллана.

2. Зардлын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Түр ажилчдад 10,170.0 мянган төгрөгийн ажлын хөлс олгохдоо нийгмийн даатгалын шимтгэл суутгаагүй байгаа нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1-д *“хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх”* гэсэн заалттай нийцэхгүй байна.

2.2. Эрсдэл:

Санхүүгийн тайланд зардал буруу илэрхийлэгдэх, нийгмийн даатгалын тухай хууль зөрчигдөх.

2.3. Өгсөн зөвлөмж:

Түр гэрээгээр ажилласан ажилтны цалин хөлснөөс нийгмийн даатгалын тухай хуулийн 17.1.1-д заасны дагуу суутгал хийж байх.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Гэрээт ажилчдаас цаашид нийгмийн даатгалын шимтгэл суутгаж ажиллах болно.

3. Дотоод хяналттай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Ажилтнууд илүү цагийн хөлс олгосон бүртгэлийг цахим цагийн бүртгэлтэй тулгахад 223.3 мянган төгрөгөөр илүү олгосон байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1 *“Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”*, 13.7-д *“Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”* гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

3.2. Эрсдэл:

Төсвийг үр ашиггүй зарцуулсан байх.

3.3. Өгсөн зөвлөмж:

Илүү цагийн хөлсийг тооцож олгохдоо цагийн бүртгэлийг цахим цагийн бүртгэлтэй тулган хянах, анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах.

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Цаашид өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

4.1. Илрүүлэлт:

2019 оны үндсэн үйл ажиллагааны орлогыг төлөвлөгөөгүй байгаа нь Сангийн Сайдын 2019 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн 74 тоот тушаалын 3.4.3-д *“Үндсэн үйл ажиллагааны буюу байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэх явцад бий болдог жил бүр давтагдах шинжтэй тогтмол орлогыг төсөвт тусгахгүй орхигдуулах”* гэсэн заалттай нийцэхгүй байна.

4.2. Эрсдэл:

Сангийн Сайдын 74 тоот тогтоолын 3.4.3-дахь заалтын *“жил бүр давтагдах шинжтэй тогтмол орлогыг төсөвт тусгахгүй орхигдуулах”* гэсэн заалт зөрчигдөх.

4.3. Өгсөн зөвлөмж:

Үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг төлөвлөж ажиллах.

4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

2019 оны төсөл хийж өгөхдөө өөрийн орлогыг төлөвлөж өгсөн боловч төсөв батлагдахдаа өөрийн орлогын төлөвлөгөө хасагдаж батлагдсан болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн САНХҮҮГИЙН ТАЙЛАН

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Данс ны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>214,469,444.28</u>	<u>340,383,186.44</u>
33	АВЛАГА	13,545,700.03	2,592,000.00
335	Бусад авлага	13,545,700.03	2,592,000.00
3351	Байгууллагаас авах авлага	13,545,700.03	2,592,000.00
34	УРЬДЧИЛГАА	00.00	21,105,810.00
3471	Урьдчилгаа тооцоо	00.00	21,105,810.00
34712	Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	00.00	21,105,810.00
35	БАРАА МАТЕРИАЛ	200,923,744.25	316,685,376.44
35300	Бэлэн бүтээгдэхүүн	42,695,802.50	56,831,451.50
354	Хангамжийн материал	158,227,941.75	259,853,924.94
35410	Бичиг хэргийн материал	5,049,000.00	7,733,400.00
35420	Аж ахуйн материал	3,850,460.00	4,756,530.00
35470	Бусад хангамжийн материал	149,328,481.75	247,363,994.94
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>8,661,746,552.03</u>	<u>8,969,647,191.54</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	8,661,746,552.03	8,969,647,191.54
392	Биет хөрөнгө	8,552,649,085.20	8,860,376,780.44
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,744,762,600.00	3,857,144,733.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-64,081,811.16
39203	Авто-тээврийн хэрэгсэл	93,915,703.75	87,133,600.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-87,709,282.88	-68,183,600.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,005,321,455.90	1,066,517,863.90
39206	Хуримтлагдсан элэгдэл	-451,079,458.71	-622,231,859.82
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	156,622,367.00	381,642,463.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-55,493,453.42	-76,768,762.04
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	4,119,264,417.00	4,272,159,417.00
39217	Ном	27,044,736.56	27,044,736.56
393	Биет бус хөрөнгө	109,097,466.83	109,270,411.10
39301	Програм хангамж	2,445,000.00	2,995,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,144,333.17	-2,521,388.90
39303	Бусад биет бус хөрөнгө	108,796,800.00	108,796,800.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>8,876,215,996.31</u>	<u>9,310,030,377.98</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>00.00</u>	<u>4,565,629.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	4,565,629.00
413	Өглөг	00.00	4,565,629.00
4136	Бусад өглөг	00.00	4,565,629.00
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	4,565,629.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>8,876,215,996.31</u>	<u>9,305,464,748.98</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	8,876,215,996.31	9,305,464,748.98
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,363,714,164.40	1,363,714,164.40

51101	Өмч: - төрийн	1,363,714,164.40	1,363,714,164.40
512	Хуримтлагдсан үр дүн	1,976,025,755.34	2,405,274,508.01
51210	Өмнөх үеийн үр дүн	1,976,025,755.34	1,974,340,299.49
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	430,934,208.52
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	5,536,476,076.57	5,536,476,076.57
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>8,876,215,996.31</u>	<u>9,310,030,377.98</u>

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/			
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,439,810,463.00	2,545,509,311.36
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	343,733,765.78	476,636,266.20
120	Нийтлэг татварын бус орлого	343,733,765.78	476,636,266.20
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	343,733,765.78	476,636,266.20
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	266,496,065.78	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	19,200,000.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	58,037,700.00	476,636,266.20
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,096,076,697.22	2,068,873,045.16
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	552,079,600.00	1,007,098,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	552,079,600.00	1,007,098,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	544,021,330.22	1,061,774,745.16
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	169,081,504.00	67,628,970.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	104,164,300.00	213,397,968.00
